



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/710

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд суудлын автомашин нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: Т.Гантулга -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын худалдан ажил худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: О.Цэрэнчимэд -аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

А.Оюунчимэг -Орон нутгийн сургалт судалгааны хөгжлийн агентлаг ТББ-ын удирдах зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)

Д.Уранцэцэг -аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны төсөв, санхүү хариуцсан ажилтан

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Гантулга) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101549

D:My Doc. Zahiramj. Zasag darga